

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны дугаар сарын....өдөр

Дугаар....

Дархан

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ ХАШАА АЖИЛЛУУЛАХ, ГУДАМЖ ЗАМ, ХАМРАХ ХҮРЭЭ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.1.7, 48 дугаар зүйлийн 48.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалын 02 дугаар хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам”-ын 3 дахь хэсгийн 3.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит бус 10 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах үйл ажиллагааг Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.

2. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Тээврийн хэрэгслийг Дархан сумын нутаг дэвсгэрт зөөж шилжүүлэх гудамж зам, хамрах хүрээ, үйлчлэх цагийн хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түгжрэл саатлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоолын хоёрдугаар хавсралтад дурьдсан гудамж зам, хориглосон цагт тээврийн хэрэгслийг зогсоож бусдын хөдөлгөөнд саад учруулсан тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсүгэй.

4.Түр саатуулах хашаа /байр/-ны тус бүрийн зогсоолын /ил болон битүү зогсоолын/ нийт талбайн хэмжээ 1000 м²-аас багагүй, зориулалтын чирэгч, ачигч автомашин /Хууль зүйн сайдын 2015 оны 190 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын 3 дахь хэсгийн 3.10.1-д заасны дагуу ачих шаардлага хангасан/-ы тоо 3-аас доошгүй байхаар тогтоосугай.

5. Тогтоолыг 2022 оны дугаар сарын-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

6. Тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д даалгасугай.

7.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 10/05 дугаар тогтоолыг тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.НАСАНБАТ

Дархан-Уул аймгийн Иргэдийн
Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус
дугаар хуралдааны оны дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ ХАШАА
/БАЙР/ АЖИЛЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Нэг. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Төлбөрийн хэмжээ /нэг удаа/ |
|---|---|--------------------------------|
| 1 | Мотоцикль | 15.000 |
| 2 | Суудлын автомашин, микроавтобус /жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин | 35.000 |
| 3 | Бүх жин нь 5000 кг хүртэл ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус, трактор | 50.000 |
| 4 | Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл | 90.000 |
| 10км-ээс дээш 1км тутамд 1600 төгрөгөөр тооцно. | | |

Хоёр. Түр саатуулах хашаа /байр/-ны төлбөрийн хэмжээ

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Төлбөрийн хэмжээ /нэг хоногт/ |
|----|--|----------------------------------|
| 1. | Мотоцикль | 2.000 төгрөг |
| 2. | Суудлын автомашин, микро автобус /жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин | 4.000 төгрөг |
| 3. | Бүх жин нь 5000 кг хүртэлх ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус | 6.000 төгрөг |
| 4. | Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус | 12.000 төгрөг |
| 5. | Тусгай зориулалтын, том оврын тээврийн хэрэгсэл | 18.000 төгрөг |

Жич: Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/-нд бүртгэж авснаас хойш 24 цагийн дотор буцаан авсан тохиолдолд түр саатуулах хашаа /байр/-ны төлбөрөөс чөлөөлнө.

Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын ээлжит бус 10 дугаар хуралдааны 2018 оны
10/05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ДАРХАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЗӨӨЖ
ШИЛЖҮҮЛЭХ ГУДАМЖ ЗАМ, ХАМРАХ ХҮРЭЭ, ҮЙЛЧЛЭХ ЦАГ

| № | Гудамж замын нэр | Хамрах хүрээ | Үйлчлэх цаг |
|---|---|-------------------------------|-------------------------------|
| 1 | “DBS” телевизийн зүүн урд талд байрлах 4 замын уулзвараас ОХУ-ын Ерөнхий консулын газрын зүүн урд байрлах 4 замын уулзвар хүртэлх зам | Зорчих хэсгийн 2 талын урсгал | 07.00-21.00 цагийн хооронд |
| 2 | ДСЦТС ХК-ийн нэрэмжит “Жаргалантын гудамж”-ны АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургуулийн хойно байрлах 4 замын уулзвараас “Ариг банк”-ны урд байрлах зогсоол хүртэл | Зорчих хэсгийн 2 талын урсгал | 07.00-21.00 цагийн хооронд |
| 3 | “Ардын өргөн чөлөө” гудамжны Дархан-Уул аймаг дахь Давж заалдах шатны шүүхийн зүүн урд байрлах 4 замын уулзвараас “Буян зах”-ын баруун талын 4 замын уулзвар хүртэл | Зорчих хэсгийн 2 талын урсгал | 07.00-21.00 цагийн хооронд |

Жич: “Үйлчлэх цаг”-ийн хязгаар нь Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн үйлдэлд хамаарахгүй болно.

-----oOo-----